

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ:

Ч.ГҮНЖДАВГА



### Тавантолгой ХК-н аж ахуйн шинэ газарт барих хашааны ажлын даалгавар

#### Зориулалт:

Тавантолгой ХК-н аж ахуйн хашаан байгаа эд хөрөнгийг хамгаалах, маршрутын бус газраар зам харгуй гарахаас сэргийлэх.

#### Ерөнхий шаардлага:

Ажлыг гүйцэтгэх явцад бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм журам, стандартыг чанд баримталж, хийгдэх ажлыг тоо хэмжээний дагуу, захиалагч талтай нягт хамтран, чанарын шаардлагыг хангаж ажиллана.

Хашааны хэмжээ: 400 метр

#### Хашаанд тавигдах техникийн шаардлага:

№	Хашааны иж бүрдэлд орох зүйл	Захиалагчийн техникийн даалгавар
1	Үндсэн хашаа	Хашааны өндөр 180 см, хашааны сараалж төмрийн хоорондох зай 10 см-с илүүгүй байх, хашааны материал зэвэрдэггүй сайн байх, хашаа хоорондын тулгуур шон нь 3.5 мм-ээс багагүй зузаантай, 5-10 см квадрат төмөр шон байх, шон хоорондын зай 4 метрээс илүүгүй байх. Шонгийн суурийг тухайн газрын хөрсний нөхцөлөөс хамааруулан газарт /40-50 см/-ээс багагүй гүн суулгаж БМ150 маркийн бетон зууртагаар чигжиж бэхэлсэн байна. Хашааг нийтэд нь цайвар, саарал өнгийн ганддаггүй будгаар будсан байх. Хашааны шон бүр дээр лог буюу бөөрөнхий толгой хийх. Том хаалганаас хоёр тийш гурав, гурван хашаанд Тавантолгой ХК-н үндсэн лого-г голлуулж байрлуулж хийх.

2	<p align="center"><b>Машин орох хаалга</b></p>	<p>Машин орох хаалганы өргөн нь 5 метр, өндөр нь хашаатайгаа адилхан 1.80 см байна. Хаалганы шонг 15-20 см квадрат төмрөөр хийнэ. Квадрат төмрийн зузаан нь 3-5 мм байна. Хаалганы гадна рамыг 40-20 мм-н төмрөөр хийнэ. Хаалганууд цүүтэй, зүүдэг цоожтой байх, хаалга нь гүйж онгойдог байхаар хийнэ. Хаалганы шонгийн газарт суух гүн 80 см-с багагүй байж БМ150 маркийн бетон зуурмагаар цутгаж шонг бэхэлж өгнө.</p>
3	<p align="center"><b>Жижиг явган хаалга</b></p>	<p>Явган хаалга нь 3-5 мм бүдүүн төмөр материалаар хийгдэнэ. Хаалганы гадна рам нь 40x20 мм-н төмрөөр хийсэн байх. Явган хаалганы өргөн нь 1 метр, өндөр нь 1.80 см байна. нугастай, цүүтэй цоожтой байна.</p>
4	<p align="center"><b>Бусад тавигдах шаардлага</b></p>	<p>Ажилд хэрэглэгдэх материал нь хэрэглээгүй шинэ, ашиглагдаагүй тохирлын гэрчилгээтэй байна. Монгол улсын үндэсний стандартыг хангах материалаар хийж гүйцэтгэнэ. Ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын бүх үе шатыг захиалагчид үзүүлж фото зургаар баталгаажуулан авна. Ажлыг гүйцэигэж дуусаад техникийн шаардлага хангасан гэж үзвэл захиалагчид ажлын ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдэж хүлээлгэж өгнө. Материалын сонголт, өнгийг тухай бүр захиалагчтай зөвлөж, техникийн тодорхойлолтод заагдсан болон түүнтэй адил чанартайг сонгож хэрэглэнэ. Ажлаас гарсан хог хаягдлыг цэвэрлэн зөөж хаян захиалагчид хүлээлгэж өгнө.</p>